

### Оюун ухааны гайхамшигийг илтгэсэн оньсон шатар

Өнө эртнээс өвөг дээдсээс маань уламжлагдан ирсэн монгол шатрыг хэлбэрийн нь хувьд сонгодог урлаг болгож дэлхийн “дэвжээнд” гаргасан хүн бол Монгол улсын урлагийн гавъяат зүтгэлтэн, Оньслох ухааны Олон улсын академийн удирдах зөвлөлийн гишүүн **З.Түмэн-Өлзий** юм. Түүний олон жилийн нэр их хөдөлмөрийн үр дүнд буй болсон оюуны бүтээлүүд болон 130 гаруй орны 11000 үзмэртэй сантай “Оюуны ухааны олон улсын музей” 20 шахам жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа ажээ.

Музейн шатрын сэдэвт танхимд 12 жилээр бүтээсэн эртний монгол шатар, XVIII зууны үед хүрэлээр цутгасан монгол шатар, Монголын төр, нийгмийн зүтгэлтэн **Ж.Самбуу**, нэрт шатарчин **Ж.Лхагва** нарын тоглож байсан шатар, ганцхан монголд л байгаа шүрэн шатар, хамгийн жижигхэн ясан монгол шатар, Их монгол улс байгуулагдсны 800 жилийн ойд зориулж урласан 7,6 м хэмжээтэй дэлхийн хамгийн том оньсон шатар, хөгжмийн зэмсгийн ба сумо бөхийн сэдэвт ясан шатрууд зэрэг 200 гаруй нэр төрлийн шатар үзмэрт тавигдснаас 40 гаруй нь дэлхийд анхдагч бөгөөд 25 нь оньсон хийцтэй юм байна.



Оньслох ухааныг ашиглан алт, мөнгө, олон төрлийн үнэт чулуу, модоор бүтээсэн монгол шатрын иж бүрдлийн дүрсүүдийн 160 эд ангиуд нь огторгуйн гурван тэнхлэгт огтлолцон гүйж 18 хүртэлх оньсоор өөр хоорондоо дахин давтагдахгүй аргаар угсрагдаж задардагаараа оюун ухааны, сийлбэрийн зохиомжоороо урлагийн гайхамшигт бүтээлд зүй ёсоор багтдаг ажээ. Энэ шатрын зөвхөн ноёнг 10 минутад угсарсан хүнд өгөх 10000 долларын бооцоот тэмцээнд дэлхийн 180 шахам орны төлөөлөгчид оролцоод байгаа боловч одоогоор тус бооцоог хожсон хүн хараахан гараагүй гэнэ.

Энэ шатрын модоор бүтээсэн нэг хувийг 1998 онд Элстэйд явагдсан Дэлхийн шатрын олимпиадын үеэр ОУШХ-д (FIDE) бэлэглэхэд, ерөнхийлөгч **К.Илюмжинов** “сая доллараар ч үнэлэхийн аргагүй оюун ухаан, соёл урлагийн ховор бүтээл” гэж дүгнээд зохион бүтээгчийг нь Дэлхийн шатрын хөдөлгөөний хөгжилд том хувь нэмэр орууллаа хэмээн “Хүндэт жуух”-аар шагнажээ.

Монголын оюун ухааны гайхамшигийг илэрхийлсэн оньсон шатрууд нь дэлхийн 50 гаруй оронд зохиогдсон 80 шахам үзэсгэлэн, яармаг худалдаанд амжилттай оролцож Гран при шагнал, алт, хүрэл медаль удаа дараа хүртжээ.

Миний бие шатрын урлагийг илэрхийлэгч - бодлого зохиомжоор нь оролддогийн хувьд оньсон шатруудыг илүүтэй бишрэн сонирхож заримаас нь Уншигчид, шатар сонирхогч нартаа товчхон мэдээлэхийг зорьсон маань энэ билээ.

ярилцаж сурвалжилсан **Л.ТОГООХҮҮ**